



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/787


Арвайхээр

**Онцгой комиссын хариуцлагатай
эргүүл ажиллуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд ажиллах аймгийн онцгой комиссын гишүүдийн хариуцлагатай эргүүлийн ажиллах журмыг нэгдүгээр, ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аймаг, сумдын удирдлага, ард иргэдэд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээллийг тогтмол хүргэж, болзошгүй гамшгийн үед гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын удирдлагыг мэргэжлийн удирдлагааар хангаж, үүрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.
3. Шинэ жилийн баяр, амралтын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийг амгалан тайван байх нөхцөлийг хангуулж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат)-д үүрэг болгосугай.
4. Аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих эргүүл, жижүүрийг томилон ажиллуулж, Онцгой байдлын газрын 7032101 дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг тухай бүрт өгч ажиллахыг гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын удирдлага, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга нарт даалгасугай.
5. Бүх сумд болон албад, мэргэжлийн ангиуд хариуцлагатай эргүүл томилж байнгын холбоотой байж баяр, амралтын өдрүүдийн цагийн байдлын мэдээллийг шаардлагатай тохиолдолд цаг тухайд нь, мэдэгдэж байхыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой комиссын гишүүд, албад, мэргэжлийн ангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.
6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг илтгэх хуудсаар 2019 оны 1 дүгээр сарын 4-ний дотор танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101713

Аймгийн Засаг даргын 2018... оны 12
дугаар сарын 25...ны өдрийн 419/87 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХАРИУЦЛАГТАЙ ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1.Аймгийн онцгой комиссын цаашид хариуцлагатай эргүүл нь Онцгой байдлын газар дээр төвлөрч 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.

2.Хариуцлагатай эргүүлүүд үүрэг гүйцэтгэх хугацаандаа дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж тухайн өдөр хийж гүйцэтгэсэн ажлын талаар илтгэх хуудас бичиж дараагийн хариуцлагатай эргүүлд ажлаа албан ёсоор хүлээлгэн өгнө.

3.Улсын онц чухал болон галын аюултай объект, үйлчилгээний байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж тухайн байгууллагын дарга нартай байнгын холбоотой ажиллаж, шаардлагатай тохиолдолд нэгдсэн үүрэг даалгавар өгч ажиллана.

4.Хариуцлагатай эргүүл нь үүрэг гүйцэтгэх хугацаанд томоохон хэмжээний гамшиг осол, аюулт үзэгдэл, гал түймэр гарсан тохиолдолд аймгийн Засаг дарга, түүний орлогч болон Онцгой байдлын газрын даргад тогтмол мэдээлэл өгч, үүрэг чиглэл авч ажиллана.

5.Аймгийн төвийн байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлагатай эргүүл жижүүрийг удирдлагаар хангаж, үүрэг чиглэл өгнө.


6.Ажлын шаардлагаар холбогдох байгууллагын удирдлагад мэдэгдэн мэргэжлийн хүн, хүчийг дайчлан ажиллуулж болно.

7.Хариуцлагатай эргүүлийн ажиллах хугацааны унаа, шатахууны зардлыг тухайн байгууллагаас хариуцна.

8.Иргэдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг Онцгой байдлын газрын /7032101/ дугаарын утсаар тухай бүр нь мэдэгдэж, ирсэн мэдээлэл, дуудлагын мөрөөр шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллана.

9.Байгууллага аж ахуйн нэгжүүд эргүүлийн шаардсан мэдээг цаг хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй. Томилгоот жижүүрүүд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, захирамжийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд хариуцлага тооцно.

Аймгийн Засаг даргын 2018... оны 12
 дугаар сарын 25... ны өдрийн 41787 дугаар
 захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХАРИУЦЛАГАТАЙ
 ЭРГҮҮЛИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Д/д	Овог нэр	Албан тушаал	Жижүүрт гарах өдөр	Харилцах утас	Тайлбар
1	Ч.Гүнсэнхорол	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	2018.12.30	99058959	
2	Д.Нэмэхбаяр	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга		99040369	
3	Д.Шиваанүрдэв	Эрүүл мэндийн газрын дарга	2018.12.31	99027701	
4	Б.Оюунчимэг	Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дарга		99005199	
5	Д.Балданням	Тээвэр автозамын газрын дарга	2019.01.01	86665505	
6	Н.Энхболд	Зоониз өвчин судлалын төвийн дарга		99323290	
7	Н.Ширчин	Монголын Цахилгаан холбоо ХК-ийн Өвөрхангай аймгийн холбооны газрын дарга	2019.01.02	88062575	
8	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга		99984060	